

БИД ХӨГЖИЛ ТҮГЭЭНЭ



Монголдоо түлш эрчим хүчний
салбарын хөгжлийг тодорхойлогч болно.



БИДНИЙ ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ, ХӨГЖЛИЙН ҮНДЭС
БОЛСОН ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫН ҮҮСЭЛ МАНАЙ УЛСАД
1941 ОНООС ЭХТЭЙ. УЛМААР 1990 ОНД УЛСЫН НЕФТЬ
ХАНГАМЖИЙН ТОГТОЛЦОО БҮРЭН ТӨЛӨВШСӨН БӨГӨӨД 1994
ОНД НИК ХК БОЛЖ НЭРЭЭ ӨӨРЧИЛСӨН ТҮҮХТЭЙ.

Жил бүр өсөн нэмэгдэж ирсэн шатахууны хэрэгцээг хангахаар газрын тосны бүтээгдэхүүн импортлогч Петровис ХХК нь 1997 онд байгуулсан. Үүний дараа 2004 онд Петровис ХХК нь НИК ХК-ийг хувьчлан, үйл ажиллагаандаа нэгтгэснээр орон даяар хамгийн өргөн сүлжээтэй болж эх орны өнцөг, булан бүрд байрлах хэрэглэгчдэдээ чанартай бүтээгдэхүүнийг тасалдалгүй, найдвартай хүргэж байна.

Өнөөдөр Петровис ХХК нь салбартаа хэдийнээ дадлагажин, мэргэшиж, олон инженер, техникийн ажилтан, албан хаагчидтай болж, нийт 2300 гаруй

ажилтныхаа хамтын хөдөлмөрөөр салбарынхаа хөгжлийг түүчээлэн ажиллаж байна.

Бид зөвхөн шатахуун импортлоод зогсохгүй шатахууны хадгалалт тээвэрлэлт, газрын тосны хайгуул, газрын тосны бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдаа, газрын тосны хяналтын лабораторийн чиглэлээр цогц үйл ажиллагаа явуулж байна.

Бид цаашид ч Монгол Улсын эдийн засгийн тулгуур болох газрын тосны салбарын хөгжлийн төлөө улам бүр хичээнгүйлэн ажиллах болно.



ПЕТРОВИС ӨНӨӨДӨР

ЧАДВАРЛАГ, МЭРГЭШСЭН ХАМТ ОЛОН

Өргөн дэвжих ажил, өсөн нэмэгдэх амьдралын
мөнхийн хөдөлгүүрийг үл зогсоохын төлөө
Петровисийн

2300 АЖИЛТАН

өдөр бүр хэрэглэгчдэдээ чанартай бүтээгдэхүүнийг
найдвартай, тасалдалгүй хүргэсээр 80 жилийн түүхийг
бүтээлээ.



ХАМГИЙН ӨРГӨН СҮЛЖЭЭ

Бид хадгалалт, түгээлтийн хамгийн найдвартай
бүтцээр эх орныхоо өнцөг булан бүрд тархсан
Петровисийн

370 ГАРУЙ

шатахуун түгээх станцаараа дамжуулан
шатахуун түгээдэг.



БИД ТАНАЙ БАЙГУУЛЛАГЫН БИЗНЕСИЙН
ОНЦЛОГТ ТОХИРСОН ХАМГИЙН УЯН ХАТАН
НӨХЦӨЛИЙГ САНАЛ БОЛГОЖ,
ХАМТРАН АЖИЛЛАНА.

ТҮҮХЭН ЗАМНАЛ

1941

Газрын тосны салбар үүсгэн байгуулагдав.

1997

Петровис ХХК байгуулагдав.

2016

“Евро 5” шатахуун худалдаалж эхлэв.

1956

Газрын тосны бүтээгдэхүүнийг төмөр замаар нефть бааз руу тээвэрлэж эхлэв.

2004

Петровис ХХК “НИК” ХК-ийг хувьчилж авав.

2019

Гурван төрлийн ISO стандартыг нэгдмэл байдлаар нэвтрүүлэв.

1978

Нефть хангамжийн удирдах газрыг байгуулав.

2007

Салбарт анхлан ISO 9001 стандартыг Петровис ХХК нэвтрүүлэв.

2020

Барууны стандартыг Монголд нэвтрүүлсэн C24 конвенциенс дэлгүүрийг Өвөрхангай аймаг, Багануур дүүргүүдэд нээв.

1990

Улсын нефть хангамжийн тогтолцоо бүрэн төлөвшив.

2013

Петровис ХХК салбартаа анхлан бүрэн автомат агуулах ашиглалтад оруулав.

ОРОН ДАЯАР ХАМГИЙН ӨРГӨН СҮЛЖЭЭ



Бид Монгол орны 4 зүг 8 зовхист байрлах 370 гаруй
Шатахуун түгээх станцаараа дамжуулан эрхэм хэрэглэгч танд үйлчилж байна.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ



Бүх төрлийн шатахуун, битум, мазутын импорт, орон нутаг дахь шатахууны борлуулалт, бөөний худалдаа, хадгалалт, тээвэрлэлт



PETROTRAK

Хүнд даацын автомашин дугуйны импорт, худалдаа, засвар үйлчилгээ, сэлбэг



**PETROVIS
RESOURCES**

Нүүрсний давхаргын метан хий болон ашигт малтмалын хайгуул



ПЕТРОСТАР

Улаанбаатар хот дахь жижиглэн борлуулалт



ПЕТРОВИС ТОС

Тос, тосолгооны материалын импорт, борлуулалт



PETRO MATAD

Газрын тосны судалгаа, хайгуул, олборлолт, борлуулалт



**ПЕТРОВИС
ТРЕЙДИНГ**

Агуулах, лаборатори, сайт сервис



ЮниГаз
ЭКО ХЭРЭГЛЭЭ

Хийн түлшний импорт, борлуулалт, үйлчилгээ



Хамтарсан хөрөнгө оруулалттай төсөл




БИДНИЙ ДАВУУ ТАЛ

EURO 5 СТАНДАРТЫ ШАТАХУУН

Бид байгаль орчинд ээлтэй, өндөр чанарын “Евро-5” стандартын шатахууныг 2016 онд салбартаа анх удаа нэвтрүүлж, хэрэглэгчдэдээ үйлчилж эхэлсэн.



СТАНДАРТЫН АНХДАГЧ



Цетан тоо өндөр учир түлшний ноцолт дээшилнэ

Энгийн дизель түлштэй харьцуулахад хүхрийн агууламж 40 дахин бага

Хөдөлгүүрээс гарах азотын исэл 30%, бусад хорт нэгдлүүд 80% хүртэл буурна

Моторын тосны зарцуулалтыг багасгана, солих хугацааг уртасгана

Хөдөлгүүрийн элэгдлийг бууруулна
Түлш зарцуулалт багасна

Байгаль орчинд ээлтэй

“ШИНЭ ТОЛГОЙТ” БҮРЭН АВТОМАТ АГУУЛАХ



Шатахууны салбартаа анхдагч Петровис ХХК нь Монголд анх удаа бүрэн автомат, олон улсын стандартыг хангасан, хүчин чадлаараа хамгийн томд тооцогдож байгаа 44.0 сая литр багтаамжтай газрын тосны бүтээгдэхүүн хадгалах, түгээх зориулалттай “Шинэ Толгойт” агуулахыг ашиглалтад оруулж, газрын тосны бүтээгдэхүүний салбарт шинэчлэл хийсэн. Агуулахыг АНУ-ын Нефтийн Институт, АНУ-ын Галын Аюулаас хамгаалах нийгэмлэгийн стандартын шаардлагад нийцүүлэн ууршилтын алдагдалгүй, агаар, хөрс, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, хөдөлмөрийг хөнгөвчлөх техникийн шийдэл, сав, тоног төхөөрөмжүүдийг суулгаснаараа агуулахын стандартыг шинэ түвшинд гаргасан.

Давуу талууд:



5 төрлийн шатахууныг хүлээн авах хадгалах, ачих технологийн үйл ажиллагааг бүрэн автоматжуулсан



Технологийн бүх шатанд хэмжүүр, хэмжих хэрэгсэлтэй, тэдгээр нь төв удирдлагын компьютерт холбогдон шатахууны хэмжилт, тооцооллыг компьютерт гүйцэтгэдэг



Галын аюулаас урьдчилан сэргийлэх мэдээлэл дохиоллын автомат системтэй, гал гарсан тохиолдолд богино хугацаанд унтраах ус, хөөсний иж бүрэн системтэй



Видео камерын иж бүрэн системтэй



Цахилгаан, дулаан, ус хангамж, холбоо, дохиолол, үерийн хамгаалалтын далан зэрэг инженерийн иж бүрэн байгууламжтай



Хэрэглэгчдийн тав тух, хэрэгцээг бүрэн хангахад зориулсан

- 30 автоцистерний зогсоол
- Итгэмжлэгдсэн лаборатори /24/7 цаг/
- Техник, технологийн засвар үйлчилгээ засвар үйлчилгээний төв

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ



ЖИЖИГЛЭН
БОРЛУУЛАЛТ



ЗАСВАР
ҮЙЛЧИЛГЭЭ



ПЕТРОВИС
КАРТ



БӨӨНИЙ
БОРЛУУЛАЛТ



ХИЙН
ТҮЛШ



ЧАНАРЫН
ХЯНАЛТ



ТОС
ТОСОЛГОО



ШАТАХУУНЫ
ТАЛОН



ХАДГАЛАЛТ,
ТЭЭВЭРЛЭЛТ



АГУУЛАХЫН
НЭГДСЭН
СҮЛЖЭЭ



АЮУЛГҮЙ
АЖИЛЛАГААНЫ
ХЯНАЛТ



САЙТ
СЕРВИС
ҮЙЛЧИЛГЭЭ



ПЕТРОМАРТ



АВТО УГААЛГА





ЖИЖИГЛЭН БОРЛУУЛАЛТ

Бид орон даяар байрлах хамгийн өргөн сүлжээгээрээ дамжуулан хэрэглэгчдэдээ бүх төрлийн шатахууныг тасалдалгүй, найдвартай хүргэж байна.



БӨӨНИЙ БОРЛУУЛАЛТ

Бид танай байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнийг бөөний борлуулалтаар хамгийн уян хатан нөхцөлөөр олгож, хамтран ажиллахад үргэлж нээлттэй байх болно.



ТОС, ТОСОЛГОО

Петровис тос ХХК нь 2004 оноос хойш тос, тосолгооны материалын импорт, борлуулалтын үйл ажиллагааг бие даан эрхлэн явуулж, тос тосолгооны материалын үйлдвэрлэлт, чанараар тэргүүлэгч АНУ-ын "ExxonMobil" компанийн албан ёсны дистрибьютерээр ажиллаж байна.

Тус компанийн Mobil брэндийн тос тосолгооны бүтээгдэхүүн болон ОХУ-ын Ангарск, Омск, Дзержинск, Нижний Новгород зэрэг томоохон үйлдвэрүүдийн автомашин, хүнд машин механизм, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тос тосолгооны материал, тусгай шингэн зэрэг 80 орчим нэр төрлийн тос, тосолгооны материалыг импортлон борлуулж байна.



ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

Бид Монголдоо томоохонд тооцогдох, иж бүрэн тоноглогдсон, хүнд даацын автомашины засвар үйлчилгээ, сэлбэгийн төвийг байгуулан бүх төрлийн хүнд машин механизмын засвар үйлчилгээ, сэлбэг, дугуй, тос, тосолгооны материал худалдааны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.



Хүнд даацын
автомашины оношилгоо,
засвар, үйлчилгээ



БНХАУ-ын бүх төрлийн
хүнд даацын
автомашины худалдаа



Хүнд даацын
автомашины сэлбэг,
дугуй, тос, тосолгооны
материалын худалдаа



Авто тээвэр



ХИЙН ТҮЛШ

Бид Юнигаз ХХК-ийг 2005 онд хамтарсан хөрөнгө оруулалтаар байгуулан ОХУ-аас Европ стандартын шингэрүүлсэн нефтийн хийг импортлон бүхий л салбарт худалдаалж байна.



Хийн түлшний
жигжлэнгийн болон
бөөний борлуулалт



Ахуйн хэрэглээний
хийн түлш
борлуулалт



Уул уурхай,
үйлдвэрийн хийн
түлшний борлуулалт



Автогаз
борлуулалт,
үйлчилгээ



Үйлчилгээний байгууллагын хийн
түлшний суурилуулалт, худалдаа



ШАТАХУУНЫ ТАЛОН

Шатахууны талон нь Монгол орны бүх аймаг хот, сум суурин газарт байрлах шатахуун түгээх станцаас бүх төрлийн шатахуун худалдан авах боломжтой, бэлэн мөнгийг орлох бүтээгдэхүүн юм.



Петровисийн бүх ШТС-аас шатахуун худалдан авахдаа төлбөрийн хэрэгсэл болгон ашиглах



Мөнгөн дэвсгэртийг орлох өндөр зэрэглэлийн нууцлалтай, эрсдэл багатай үнэт цаас



Тээврийн хэрэгслийн онцлогт тохируулан хэрэглээгээр нь хуваарилах, ангилахад тохиромжит хувилбарууд /5,000₮ 10,000₮, 20,000₮, 50,000₮/

Худалдаалах цэгүүд:

- Улаанбаатар хотод:**
- Петровис компанийн төв байр, Картын төвд
 - ШТС-9 /Баянзүрхийн товчооны урд/
 - ШТС-10 /22-ын товчооны замд, "Монос" их сургуулийн замын ард/
 - ШТС-12 /Нисэх, Төв аймгийн замын уулзварын урд/
 - ШТС-31 /Налайх дүүргийн төв замд/

Орон нутагт:

- Бүх аймгийн төвийн нефть хангамжийн салбарт



ПЕТРОВИС КАРТ

Бид 2003 онд газрын тосны бүтээгдэхүүний зах зээлд анх удаа хэрэглэгчдийнхээ худалдан авалтыг урамшуулах, шатахууны зарцуулалтаа хянах, бодит хэмнэлт авах боломжийг олгох зорилгоор шатахууны картын төлбөрийн системийг нэвтрүүлсэн.



Хөнгөлөлт
24 цагийн дотор
орно



Үйлчилгээний
нэмэлт
шимтгэлгүй



Тогтмол
хөнгөлөлттэй



Дэлгэрэнгүй
цахим хуулга
авах



Нууцлал, аюулгүй
байдлын олон улсын
стандарт системтэй



Онлайнаар
хэрэглээгээ
хянах

*Хөнгөлөлт

Бид танай байгууллагын бизнесийн онцлогт тохирсон хамгийн уян хатан нөхцөлийг санал болгож, хамтран ажиллана.

ШИЛДЭГ ЧАНАРЫГ БАТАЛГААЖУУЛАВ



Бүтээгдэхүүнийг хүлээн авахаас хэрэглэгчдэд хүргэх хүртэл хадгалалт, тээвэрлэлт, ачилт буулгалтын үе шат бүрд итгэмжлэгдсэн 9 лабораториор баталгаажуулж, чанарын хяналтыг хэрэгжүүлдэг.





ЧАНАРЫН ХЯНАЛТ

Бид технологийн үе шат бүрд чанарын хяналтын тогтолцоог хэрэгжүүлснээр хэрэглэгчдэдээ чанартай, баталгаатай бүтээгдэхүүнүүдийг найдвартай, тасалдалгүй хүргэж байна.

Энэхүү чанарын хяналтын тогтолцооны гол хэсэг болох газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын 9 лабораторийг Монгол Улсын бүс нутаг бүрд ажиллуулж байгаагаас Улаанбаатар хот дахь “Шинэ Толгойт” агуулах нь салбартаа анхлан Улсын итгэмжлэлийг хүлээн авч, бусад лабораторийнхаа шинжилгээ, үйл ажиллагааг давхар баталгаажуулан ажиллаж байна. Манай лабораториуд нь олон улсын ISO, АНУ-ын ASTM, ОХУ-ын ГОСТ, Монгол Улсын MNS стандарт аргачлалын дагуу шаардлага хангасан тоног төхөөрөмж дээр чанарын 21 үзүүлэлтийг тогтмол тодорхойлон ажиллаж байна.



ХАДГАЛАЛТ ТЭЭВЭРЛЭЛТ

Бид шатахууныг ОХУ-аас импортолж, хэрэглэгчдэд хүргэхдээ хадгалалт, тээвэрлэлтийн хамгийн найдвартай тогтолцоог мөрдөн ажилладаг. Стандарт хэмжил зүйн газрын баталгаатай, 24/7 цагийн хяналтын GPS системтэй 300 автоцистерн ажиллаж, чанартай шатахууныг тээвэрлэн хэрэглэгчдэд хүргэж байна.

Түүнчлэн бүтээгдэхүүнээ чанарын баталгаатай хүргэх үүднээс өөрийн агуулахуудад байрлах 9 лабораторид шинжлэн баталгаажуулдаг.

Шатахууныг хүлээн авахаас эцсийн хэрэглэгчид хүрэх хүртэл хадгалалт, тээвэрлэлт, ачилт/ буулгалтын бүх үе шат дамжлагыг технологи, аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан мэргэжлийн баг гүйцэтгэж байна.

Манай давуу талууд:



100 САЯ
ГАРУЙ ЛИТР

Хадгалалт, нөөцийн хамгийн том сүлжээ (3-6 төрлийн шатахуун хадгалах боломжтой, 100 сая гаруй литрийн багтаамж бүхий 11 газрын тосны бүтээгдэхүүний агуулах)



300

Стандарт хэмжилзүйн газрын баталгаатай, 24 цагийн хяналтын GPS системтэй 300 автоцистерн



9


Өөрийн агуулахуудад байрлах 9 лаборатори

Бид хамгийн чанартай бүтээгдэхүүнийг, хамгийн өргөн сүлжээгээр буюу орон даяар байрлах 370 гаруй шатахуун түгээх станцаараа дамжуулан 24/7 цагийн горимд найдвартай, тасалдалгүй хүргэж байна.



АГУУЛАХЫН НЭГДСЭН СҮЛЖЭЭ

Бид улсын хэмжээнд 3-6 төрлийн шатахуун хадгалах боломжтой, 100 сая гаруй литрийн багтаамж бүхий 11 агуулахтай. Агуулахууд нь эдийн засгийн хөгжлийн бүс, тулгуур төвүүд, хилийн боомт зэрэг дэд бүтэц хөгжсөн, чухал шаардлагатай газруудад байрладаг. Агуулахууд нь байгаль орчинд ээлтэй, хүний оролцоог багасгасан Монгол Улсын стандартын дагуу технологийн горим, аюулгүй ажиллагааг баримтлан үйл ажиллагаагаа явуулж байна.





БОЛОМЖОО АШИГЛА



Хувь хэрэглэгчийн худалдан авалтын үнийн дүнд
суурилсан оноо цуглуулах урамшуулалт хөтөлбөр





САЙТ СЕРВИС ҮЙЛЧИЛГЭЭ

Байгууллага хэрэглэгчдэдээ санал болгодог хамгийн хэрэгцээт үйлчилгээний нэг болох Сайт сервис үйлчилгээний давуу талуудыг танилцуулж байна.



Шатахуун хангамжийн үйл ажиллагааг зохион байгуулах



Газрын тосны бүтээгдэхүүний нөөц хадгалж, хямрал эрсдэлээс сэргийлэх боломж олгох



Шатахууны чанарыг зөөврийн лабораториор баталгаажуулах




Танай байгууллагын ажлын талбарт газрын тосны бүтээгдэхүүн хадгалах сав барих, тоног төхөөрөмж суурилуулах, техникийн засвар үйлчилгээ хийх



Газрын тосны чиглэлээр мэргэжлийн сургалт, зөвлөгөө өгөх



24/7 түгээлтийн баг өндөр нарийвчлал бүхий хэмжих тоолууртай, зориулалтын автоцистернээр уул уурхайн машин, механизмыг шатахуунаар цэнэглэх



REDPOINT ЛОЯАЛТИ ҮЙЛЧИЛГЭЭ

RedPoint лоялти үйлчилгээ нь Петровисийн хувь хэрэглэгчдэд зориулсан оноонд суурилсан урамшуулалт хөтөлбөр юм.

Хэрэглэгч Петровисийн орон даяар байрлах 370 орчим орчим шатахуун түгээх станцаас худалдан авалт хийхэд таны дансанд урамшууллын RedPoint оноо хуримтлагдана.

Хэрэглэгчид хуримтлуулсан оноогоороо шатахуун болон цахим дэлгүүрээс өөрийн хэрэглээнд нийцсэн бүтээгдэхүүнээ худалдан авах боломжтой.

🌐 www.redpoint.mn

📱 [redpoint mongolia](#)





АВТО УГААЛГА

Бид дэлхийн шилдэг брэнд, ХБНГУ-ын "Washtec" технологийн бүрэн автомат үйл ажиллагаатай, байгаль орчинд ээлтэй, авто угаалгын газрыг 2015 онд "Petro car wash" нэрээр ашиглалтад оруулан, хэрэглэгчдэдээ үйлчилж байна.

Давуу талууд:

Хамгийн чанартай брэнд угаалгын бодистой хослуулсан шат дараатай төгс угаалга

Толбогүй, гялалзсан хатаалга нь машины өнгийг хамгийн удаан хадгална

Дээд зэргээр гялалзуулах WAX өнгийг хамгийн сайн хамгаална

Хамгийн хурдан шуурхай буюу 5-8 минутад бүрэн угаана

Байгаль орчинд ээлтэй технологи ашигладаг тул ердөө 3 литр усаар автомашиныг бүрэн угааж дуусна

Автомашины доод хэсгийн угаалгатай



**БИД ТАНД ЧАНАРТАЙ ҮЙЛЧИЛГЭЭГ
ХУРДАН ШУУРХАЙ ХҮРГЭХ БОЛНО**

Хаяг байршил:

📍 БГД-ийн 4-р хороо, "Материал импекс"-ийн замын хойно Петровис ШТС - 28 салбар



ПЕТРОМАРТ

Улаанбаатар хотод хэрэглэгчдэдээ ойр төв зам дагуу байрлалтай 12 салбар бүхий Петромарт сүлжээ дэлгүүр 24/7 цагаар үйлчилгээгээ үзүүлсээр байна. Тус сүлжээ дэлгүүр нь аян замын хэрэгцээт хүнс, бараа, Mobil брэнд болон бусад төрлийн тос, тосолгооны материал, автомашины жижиг оврын сэлбэг, автохимийн бараа гэх мэт төрөл бүрийн хэрэгцээт бүтээгдэхүүнээр мөн халуун цай, кофе, бэлэн бүтээгдэхүүнээр үйлчлэхээс гадна, дэлгүүрүүд дотоод сүлжээгээр холбогдсон байдаг. Хэрэглэгч таны хэрэгцээт бараа аль чиглэлд хамгийн ойр байгаа талаар мэдээллээр хангах боломжтой.

Хаяг байршил:

- 📍 **Петромарт-1**
БГД-ийн 4-р хороо, Гурвалжингийн гүүрний баруун хойд талд
- 📍 **Петромарт-10**
СХД-ийн 20-р хороо, 22-ын товчооны наана зам дагуу
- 📍 **Петромарт-10**
ЧД-ийн 10-р хороо, Дэнжийн 1000 Хүчит шонхор зах орох замд
- 📍 **Петромарт-4**
ЧД-ийн 8-р хороо, Тасганы овооны баруун талд
- 📍 **Петромарт-14**
БГД-ийн 19-р хороо, 4-р хороолол Өргөө кино театрын замын урд талд
- 📍 **Петромарт-39**
СХД-ийн 32-р хороо Эмээлт явах зам дагуу



КОНВЕНИЕНС ДЭЛГҮҮР



Бид Монгол анх удаа 24/7 цагийн автомашинтайгаа үйлчлүүлдэг C24 конвениенс дэлгүүрийг ашиглалтад орууллаа. Автоматжуулалтын чиглэлээр дэлхийд тэргүүлэгч АВВ Группийн түргэн цэнэглэгч цахилгаан түгээгүүр ажиллаж, цахилгаан автомашин цэнэглэж байна.

Мөн бүх банкны АТМ-аар үйлчлүүлэн, автомашинаасаа буулгүй халуун кофе, түргэн хоол авах боломжийг бид бүрдүүллээ.

Петровис ХХК нь 50 мянга гаруй харилцагчтай бөгөөд таныг бидний эгнээнд нэгдэн улсынхаа хөгжлийн төлөө хамтдаа ажиллана гэдэгт найдаж байна.

Хаяг байршил:

- 📍 СБД-ийн 1-р хороо, Энхтайваны гүүрний баруун хойно ШТС-29 салбар
- 📍 Багануур дүүрэг Петровис ШТС
- 📍 Өвөрхангай аймаг Хархорин Петровис ШТС



АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ

Бид үйл ажиллагаандаа бизнесийн байгууллагын чанарын удирдлагын тогтолцооны олон улсын стандарт болох ISO 9001:2015, байгаль орчны удирдлагын системийн үйл ажиллагааны шаардлагуудад чиглэгдсэн ISO 14001:2015 болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны стандарт OHSAS 18001:2017 стандартуудыг нэгдмэл байдлаар цогцоор нь амжилттай нэвтрүүлэн үйл ажиллагаандаа байнгын мөрдлөг болгон амжилттай хэрэгжүүлэн, ажиллаж байна.



Хөдөлмөрийн аюулгүй байдал,
эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны
стандарт ISO 45001:2018

Чанарын удирдлагын
тогтолцооны олон улсын
стандарт ISO 9001:2015

Байгаль орчны удирдлагын системийн
үйл ажиллагааны шаардлагуудад
чиглэгдсэн ISO 14001:2015



ХАДГАЛАЛТ, ТҮГЭЭЛТИЙН **ХАМГИЙН НАЙДВАРТАЙ** БҮТЭЦ




Улаанбаатар хот, 21 аймагт байрлах орчин үеийн технологи бүхий агуулахуудаас жил бүр 6,000,000 км замыг туулж, Монгол орны өнцөг булан бүрд шатахуун түгээдэг.



ТОП АЖ АХУЙН НЭГЖ

Манай Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан Петровис ХХК нь шилдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын эхний аравт тогтмол эрэмбэлэгддэг. Петровис болон түүний харъяа компаниуд 2004 оноос эхлэн Монгол Улсын ТОП-100 аж ахуйн нэгжид тоонд нийт 33 удаа бахархам шалгарсан амжилттай юм.



СҮҮЛИЙН 5 ЖИЛД ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ ТУС БҮРЭЭР ШАЛГАРСАН БАЙДАЛ

		2015	2016	2017	2018	2019
	Улсад төлсөн татварын хэмжээгээр	5	4	8	6	4
	Борлуулалтын орлогоор	6	8	9	7	8
	Даатгуулагчийн буюу ажиллагсдын тоогоор	21	18	18	19	20
	Хөрөнгийн хэмжээгээр	31	35	37	44	44
	Ашгийн хэмжээгээр		42	59	66	74

		2015	2016	2017	2018	2019
	Улсад төлсөн татварын хэмжээгээр	9	6	27	26	21
	Борлуулалтын орлогоор	20	30	35	33	39
	Даатгуулагчийн буюу ажиллагсдын тоогоор	53	44	52	60	66
	Хөрөнгийн хэмжээгээр	46	52	50	54	56
	Ашгийн хэмжээгээр		47	81	74	71



EURO 5

СТАНДАРТЫН АНХДАГЧ



Хурдыг чанараас, Чанарыг Euro5-аас

Super
98

Premium
95

Euro 5
92

Euro 5
ДТ